



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: СЭА-2024/204/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.selenge@audit.gov.mn

Сүхбаатар сум
2024 он

Дарга, тэргүүлэх аудитор: Ч.Энхтуяа

Утас: 70363040 Цахим хаяг: enkhuyach@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Батмөнх

Утас: 70363036 Цахим хаяг: batmunkhb@audit.gov.mn

Аудитор: Б.Ундаръяа

Утас: 70376994 Цахим хаяг: undariya@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. АУДИТЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
3.1. Байгууллага, түүний үйл ажиллагаа	12
3.2. Байгууллагын гадаад, дотоод орчин	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ..	13
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.6.1 Төсвийн төлөвлөлт	15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл	15
3.6.3 Нэмэлт төсөв	16
3.6.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	17
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл.....	17
4.2. Материаллаг байдал	18
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	18
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	18
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд	19
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	19
4.5.1 Завсрын аудитын талаар	19
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	19
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	20
5.2 Албан шаардлага	21
5.2 Зөвлөмж	22
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	22

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол, шинжлэх ухааны сайд
БШУЯ	Боловсрол, шинжлэх ухааны яам
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
ЗГБХН	Зарим гишүүд нь бүрэн хариуцлагатай нөхөрлөл
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СӨБ	Сургуулийн өмнөх боловсрол
ТББ	Төрийн бус байгууллага
ТБОНӨХБАУХА	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах



СЭЛЭНГЭ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

II баг, Цагаан эрэг, Сүхбаатар сум,
Сэлэнгэ аймаг, 43081
Утас/Факс: (976)-7036-3040
Цахим шуудан: Selenge@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

САНТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ӨЛЗИЙ-БАДРАХ ТАНАА

2024.02.23 № СЭА-2024/204/НА-СТА-ТШЗ
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд тус сургууль нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,997,500.9 мянган төгрөгийн 100 хүүхдийн дотуур байр, 34,307.3 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, сумын ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 44,200.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, БШУЯ-аас 1,812.8 мянган төгрөгийн ном, Дэлхийн зөн ОУБ-аас 24,511.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж зэрэг нийт 2,102,332. мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Тус сургууль нь Боловсролын Ерөнхий газрын даргын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн А/324 дүгээр тушаалаар сургалтын байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний үр дүнгээр 1 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулалд **20,851.5** мянган төгрөгийн санхүүжилт авч зарцуулсан байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд мөрдөж байгаа БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” нь гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

Байгууллагын төсөв, санхүүжилтийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна.

Бусад асуудлын хэсэг

Тус байгууллага нь тайлант оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд **4** зорилтын хүрээнд **32** арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, **91.8** хувийн гүйцэтгэлтэй үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭНХТУЯА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	86,676,659.51	149,255,980.13
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,255,456.60	50,705,978.38
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө	3,255,456.60	50,705,978.38
31210	Төгрөг	3,255,456.60	50,705,978.38
31211	Төрийн сангийн харилцах	3,255,456.60	50,705,978.38
35	БАРАА МАТЕРИАЛ	83,421,202.91	98,550,001.75
35400	Хангамжийн материал	83,421,202.91	98,550,001.75
35420	Аж ахуйн материал	12,600.00	0.00
35460	Хүнсний материал	6,522,238.00	3,802,400.00
35470	Бусад хангамжийн материал	76,886,364.91	94,747,601.75
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,946,830,661.89	4,965,166,509.82
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,946,830,661.89	4,965,166,509.82
39200	Биет хөрөнгө	2,907,852,161.78	4,926,438,009.67
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,030,247,484.00	5,027,748,426.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(300,919,953.35)	(367,558,458.89)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	29,562,500.00	29,562,500.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(29,562,500.00)	(29,562,500.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	210,625,297.16	274,351,342.16
39206	Хуримтлагдсан элэгдэл	(152,467,776.16)	(158,341,900.01)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	123,728,971.68	167,358,106.15
39208	Хуримтлагдсан элэгдэл	(77,899,276.65)	(84,653,427.38)
39214	Бусад үндсэн хөрөнгө	12,361,159.55	12,361,159.55
39215	Хуримтлагдсан элэгдэл	(4,705,360.51)	(6,136,095.97)
39217	Ном	66,881,616.06	61,308,858.06
39300	Биет бус хөрөнгө	38,978,500.11	38,728,500.15
39301	Программ хангамж	1,500,000.00	1,500,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(937,499.89)	(1,187,499.85)
39303	Бусад биет бус хөрөнгө	38,416,000.00	38,416,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,033,507,321.40	5,114,422,489.95
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	4,028,094.79	913,400.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	4,028,094.79	913,400.00
41300	Өглөг	4,028,094.79	913,400.00

41310	Ажилчидтай холбогдсон өглөг	1,669,207.79	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,123,665.00	913,400.00
41360	Бусад өглөг	1,235,222.00	0.00
41361	Байгууллагад төлөх өглөг	1,235,222.00	0.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,029,479,226.61	5,113,509,089.95
51	Засгийн газрын хувь оролцоо	3,029,479,226.61	5,113,509,089.95
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,052,161,520.45	1,052,161,520.45
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	1,052,161,520.45	1,052,161,520.45
51200	Хуримтлагдсан үр дүн	(763,985,150.57)	1,320,044,712.77
51210	Өмнөх үеийн үр дүн	(3,793,464,377.18)	(763,985,150.57)
51220	Тайлант үеийн үр дүн	3,029,479,226.61	2,084,029,863.34
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,741,302,856.73	2,741,302,856.73
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,033,507,321.40	5,114,422,489.95

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	/төгрөгөөр/	
		ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	4,056,468,123.37	3,416,993,084.56
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,092,148,095.38	2,128,352,873.87
120	Нийтлэг татварын бус орлого	3,092,148,095.38	2,128,352,873.87
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,444,016.00	9,001,768.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,444,016.00	1,356,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,645,568.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,000,975,321.56	2,102,332,015.47
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	89,728,757.82	17,019,090.40
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	964,320,027.99	1,288,640,210.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	767,995,800.00	1,052,094,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	767,995,800.00	1,052,094,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	196,324,227.99	236,546,010.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	196,324,227.99	236,546,010.69
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,026,988,896.76	1,322,188,729.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,026,988,896.76	1,322,188,729.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	978,818,054.76	1,262,472,614.88
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	589,696,607.71	733,343,714.72

210101	Үндсэн цалин	407,182,286.65	524,527,308.58
210102	Нэмэгдэл	151,417,395.91	168,879,895.35
210104	Урамшуулал	28,288,850.15	39,936,510.79
210105	Гэрээт ажлын хөлс	2,808,075.00	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,925,780.48	91,561,183.92
210201	Тэтгэврийн даатгал	50,346,906.31	62,086,572.59
210202	Тэтгэмжийн даатгал	5,928,827.10	7,350,886.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,706,101.66	5,876,112.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,178,691.16	1,467,243.34
210205	Эрүүл мэндийн даатгал	11,765,254.25	14,780,369.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,732,947.59	228,653,410.69
210301	Гэрэл, цахилгаан	12,720,950.74	13,351,726.70
210302	Түлш, халаалт	146,593,996.85	212,884,083.99
210303	Цэвэр, бохир ус	2,418,000.00	2,417,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	637,600.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	637,600.00	0.00
2105	Нормативт зардал	35,401,490.00	54,065,759.20
210502	Хоол, хүнс	35,401,490.00	54,065,759.20
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,600.00	13,492,600.00
210604	Урсгал засвар	445,600.00	13,492,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,877,000.00	6,613,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,386,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,877,000.00	5,226,700.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	113,101,028.98	134,742,446.35
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	24,862,927.91	24,265,775.25
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,618,441.40	8,171,595.40
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	79,619,659.67	102,305,075.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	48,170,842.00	59,716,114.50
2132	Бусад урсгал шилжүүлэг	48,170,842.00	59,716,114.50
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	37,696,142.00	38,864,613.80
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,474,700.00	20,851,500.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	3,029,479,226.61	2,094,804,355.18
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	0.00	10,774,491.84

225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	10,774,491.84
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	3,029,479,226.61	2,084,029,863.34

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	965,764,043.99	1,297,641,978.69
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,444,016.00	9,001,768.00
120	Нийтлэг татварын бус орлого	1,444,016.00	9,001,768.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	1,444,016.00	9,001,768.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,444,016.00	1,356,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	7,645,568.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	964,320,027.99	1,288,640,210.69
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	767,995,800.00	1,052,094,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	767,995,800.00	1,052,094,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	196,324,227.99	236,546,010.69
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	196,324,227.99	236,546,010.69
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	937,033,587.39	1,221,108,056.91
21	УРСГАЛ ЗАРДАЛ	937,033,587.39	1,221,108,056.91
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	892,405,027.39	1,161,750,756.21
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,332,886.61	734,719,623.33
210101	Үндсэн цалин	406,353,574.59	525,903,217.19
210102	Нэмэгдэл	151,206,893.64	168,879,895.35
210103	Унаа хоолны хөнгөлөлт	0.00	0.00
210104	Урамшуулал	28,288,849.46	39,936,510.79
210105	Гэрээт ажлын хөлс	2,483,568.92	0.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,620,293.79	91,854,483.19
210201	Тэтгэврийн даатгал	50,079,107.79	62,379,871.86
210202	Тэтгэмжийн даатгал	5,891,571.50	7,350,886.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,706,557.17	5,876,112.02
210204	Ажилгүйдлийн даатгал	1,176,614.33	1,467,243.34
210205	Эрүүл мэндийн даатгал	11,766,443.00	14,780,369.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	161,732,947.59	228,653,410.69

210301	Гэрэл, цахилгаан	12,720,950.74	13,351,726.70
210302	Түлш, халаалт	146,593,996.85	212,884,083.99
210303	Цэвэр, бохир ус	2,418,000.00	2,417,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	637,600.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	637,600.00	0.00
2105	Нормативт зардал	34,405,300.00	52,828,400.00
210502	Хоол, хүнс	34,405,300.00	52,828,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	445,600.00	13,492,600.00
210604	Урсгал засвар	445,600.00	13,492,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,877,000.00	6,613,673.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.00	1,386,800.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,877,000.00	5,226,873.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	29,353,399.40	33,588,566.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,295,900.00	25,417,666.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,057,499.40	8,170,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,628,560.00	59,357,300.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,628,560.00	59,357,300.70
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	34,153,860.00	38,505,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	10,474,700.00	20,851,500.70
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	28,730,456.60	76,533,921.78
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	25,475,000.00	29,083,400.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	25,475,000.00	29,083,400.00
2200	Дотоод эх үүсвэрээр	25,475,000.00	29,083,400.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	25,475,000.00	29,083,400.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(25,475,000.00)	(29,083,400.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	3,255,456.60	47,450,521.78
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	3,255,456.60
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	3,255,456.60	50,705,978.38

2.4 Аудит хийсэн ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	0.00	0.00	0.00	0.00
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	1,052,161,520.45	2,741,302,856.73	(3,793,464,377.18)	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	(3,793,464,377.18)	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	3,029,479,226.61	3,029,479,226.61
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	(763,985,150.57)	3,029,479,226.61
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	(763,985,150.57)	3,029,479,226.61
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	(763,985,150.57)	3,029,479,226.61
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	2,084,029,863.34	2,084,029,863.34
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,052,161,520.45	2,741,302,856.73	1,320,044,712.77	5,113,509,089.95

2.5 Аудит хийсэн ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,300,897,434.69	1,250,191,456.31	50,705,978.38	96.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,300,897,434.69	1,250,191,456.31	50,706,043.78	96.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,300,897,434.69	1,250,191,456.31	50,706,043.78	96.1
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	776,525,924.00	734,662,422.73	41,863,566.67	94.6
210101	Үндсэн цалин	541,201,224.00	525,846,016.59	15,355,272.81	97.2
210102	Нэмэгдэл	195,352,000.00	168,879,895.35	26,472,104.65	86.4

210104	Урамшуулал	39,972,700.00	39,936,510.79	36,189.21	99.9
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	96,877,100.00	91,854,483.19	5,022,616.81	94.8
210201	Тэтгэврийн даатгал	65,876,400.00	62,379,871.86	3,496,528.14	94.7
210202	Тэтгэмжийн даатгал	7,750,100.00	7,350,886.80	399,213.20	94.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,200,100.00	5,876,112.02	323,987.98	94.8
210204	Ажилгүйдлийн даатгал	1,550,100.00	1,467,243.34	82,856.66	94.7
210205	Эрүүл мэндийн даатгал	15,500,400.00	14,780,369.17	720,030.83	95.4
	Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал	228,653,410.69	228,653,410.69	-	
210301	Гэрэл, цахилгаан	13,351,726.70	13,351,726.70	-	
210302	Түлш, халаалт	212,884,083.99	212,884,083.99	-	
210303	Цэвэр, бохир ус	2,417,600.00	2,417,600.00	-	
	Эд хогшил, урсгал засварын зардал	7,892,600.00	7,892,600.00	-	
210604	Урсгал зардал	7,892,600.00	7,892,600.00	-	
2105	Нормативт зардал	58,428,400.00	58,428,400.00	-	100
210502	Хоол, хүнс	52,828,400.00	52,828,400.00	-	100
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,790,800.00	6,670,873.00	119,927.00	98.2
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,444,000.00	1,444,000.00	-	100
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	5,346,800.00	5,226,873.00	119,927.00	97.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	62,684,200.00	62,671,966.00	12,234.00	100
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	54,513,300.00	54,501,066.00	12,234.00	100
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,170,900.00	8,170,900.00	-	100
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	63,045,000.00	59,357,300.70	3,687,699.30	94.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	63,045,000.00	59,357,300.70	3,687,699.30	94.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	42,192,600.00	38,505,800.00	3,686,800.00	91.3
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	20,852,400.00	20,851,500.70	899.3	100
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,300,897,434.69	1,297,641,978.69	3,255,456.00	99.7
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,052,094,200.00	1,052,094,200.00	-	100
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,052,094,200.00	1,052,094,200.00	-	100
	Орон нутгийн төсвөөс	236,546,010.69	236,546,010.69		
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	12,257,224.00	9,001,768.00	3,255,456.00	73.4
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,356,200.00	1,356,200.00	-	
350002	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	7,645,568.00	7,645,568.00	-	100
350003	Урьд оны үлдэгдлээс санхүүжих	3,255,456.00	0		0

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	3,255,456.60		
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	50,705,978.38		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1. БАЙГУУЛЛАГА, ТҮҮНИЙ ҮЙЛ АЖИЛЛАГАА

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь “Хүсэл тэмүүлэлтэйгээр хамтран суралцдаг, зөв харилцаа хандлагатай, эрүүл зөв дадалтай, бие даасан бүтээлч хүүхэд төвөлшүүлнэ.” гэсэн зорилт тавин ажиллаж байна.

Үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Малчин болон алслагдсан бүс нутагт амьдарч байгаа өрхийн хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн хөгжлийг хувилбарт сургал, үйл ажиллагаагаар дэмжих, 5 настай хүүхэд бүрийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулан сургуульд элсэн суралцах бэлтгэл хангах
- Тэгш хүртээмжтэй, тэгш боломж олгосон, хамтын хариуцлагатай байх суурь зарчимд тулгуурлан байршлас хамаарсан үйлчилгээний чанарын ялгааг бууруулж хүүхэд бүр гэртээ ойр байрлах цэцэрлэг, сургуульд хамрагдах хүсэл эрмэлзэлийг нэмэгдүүлэх,
- Хүүхэд бүрийн онцлог, ялгаагтай байдал, явцын үнэлгээнд суурилан сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах үйл ажиллагааг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлж сурлагын амжилтад ахиц гаргах,
- Суралцагчийн математик, англи хэлний сургалтыг дэмжих цахим технологид суурилсан нэмэлт хөтөлбөрийг бага суурь боловсролын зарим ангид хэрэгжүүлж, суралцагчийн ур чадвар, багшийн арга зүйд ахиц гаргах

3.2. БАЙГУУЛЛАГЫН ГАДААД, ДОТООД ОРЧИН

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар төсөв, санхүүжилттэй холбоотой,
- Боловсролын ерөнхий хууль 2023 оны 07 дугаар сарын 07-нд батлагдсан,
- Хөдөлмөрийн тухай хуульд 2023 оны 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2023 оны 06 дугаар сарын 16, 07 дугаар сарын 07-нд нэмэлт өөрчлөлт орсон,
- Засгийн газрын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосон,
- БШУС-ын 2023 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн 1/2714 тоот албан бичгээр боловсролын байгууллагын төсвийн шинэчлэлийн хүрээнд “1.ЕБС-д

сургалтын тоног төхөөрөмжийн нөхөн хангалт шийдвэрлэх”, “2.Цэцэрлэгт шаардлагатай хүүхдийн тоглоом, наадгай, зөөлөн эдлэл ханган нийлүүлэх, худалдан авах ажиллагааг зохион байгуулах” чиглэлийг хүргүүлсэн гэх мэт.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналт, үйл ажиллагааны зохион байгуулалтын хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Тайлант онд тус байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд БШУЯ-ны Хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын Дотоод аудитын хэлтсээс хяналт, шалгалт хийгдээгүй боловч сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, шилэн дансны мэдээллээр дамжуулан дотоод хяналт, шалгалтыг хэрэгжүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

Тус сургууль нь БШУС-ын 2021 оны 01 дүгээр сарын 26-ны өдрийн А/22 дугаар тушаалаар баталсан Боловсрол, шинжлэх ухааны салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа төсөвт байгууллагуудад мөрдөгдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн хэдий ч гүйцэтгэл, үр дүнгээр санхүүжиж байгаа байгууллагын онцлогт тохироогүй, үр дүнд суурилсан төсөвлөлт, санхүүжилт, хөрөнгө оруулалт, хөтөлбөр, арга хэмжээний бүртгэлийн талаар нарийн тусгаагүй байна.

3.4. Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,080,915.1 мянган төгрөгөөр буюу 40.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,255.40	50,705.90	47,450.50
Авлага	-	-	-
Бараа материал	83,421.20	98,550.00	15,128.80
Үндсэн хөрөнгө	2,946,830.70	4,965,166.50	2,018,335.80
Нийт хөрөнгө	3,033,507.30	5,114,422.40	2,080,915.10
Өр төлбөр	4,028.10	913.4	(3,114.70)
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	3,029,479.20	5,113,509.00	2,084,029.80
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	3,033,507.30	5,114,422.40	2,080,915.10

Дээрх хүснэгтээс харахад дараах дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна. Үүнд:

- Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 50,705.9 мянган төгрөг болж 47,450.5 мянган төгрөгөөр өссөн нь Төсвийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9¹-д заасны дагуу гүйцэтгэлд суурилсан санхүүжилтэд шилжсэнээр төсвийн хэмнэлтийг төвлөрүүлээгүйгээс,
- Бараа материал дансны үлдэгдэл 98,550.0 мянган төгрөг болж 15,128.8 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 121,472.3 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, аймгийн БШУГ-аас 2,972.7 мянган төгрөгийн түрээсийн ном, Дэлхийн зөн ОУБ-аас 12,546.5 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, сумын ОНХС-с 1,500.0 мянган төгрөгийн ном, хулдаас үнэ төлбөргүйгээр хүлээн авсан, нийт 123,362.7 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаас,
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,965,166.5 мянган төгрөг болж 2,018,335.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 29,083.4 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1,997,500.9 мянган төгрөгийн 100 хүүхдийн дотуур байр, 27,200.0 мянган төгрөгийн дотуур байрны ширээ сандал, давхар ор, 6,607.3 мянган төгрөгийн гал тогооны тоног төхөөрөмж, 500.0 мянган төгрөгийн принтер, БШУЯ-аас 1,812.8 мянган төгрөгийн ном, сумын

¹ Энэ хуулийн 7.7 дахь хэсэг эрүүл мэнд, боловсролын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн зарчмаар санхүүждэг байгууллагын төсвийн захирагчид хамаарахгүй

ОНХС-ийн хөрөнгө оруулалтаар 44,200.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, Дэлхийн зөн ОУБ-аас 24,511.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг үнэ төлбөргүй хүлээн авсан, сумын ИТХ-ын 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн 74 дугаар тогтоолоор 32,132.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга, эд хогшил, ном акталж данснаас хассан, нийт 80,947.6 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсоноос,

- Өр төлбөр дансны үлдэгдэл 913.4 мянган төгрөг болж 3,114.7 мянган төгрөгөөр буурсан нь өмнөх оны 4,028.1 мянган төгрөг /НДШ-ийн 1,669.2 мянган төгрөг, хүнсний материалын 1,123.7 мянган төгрөг, байгууллагад төлөх 1,235.2 мянган төгрөг/ -ийн өр төлбөрийг барагдуулж, тайланд онд 913.4 мянган төгрөгийн гэрэл цахилгаан, цэвэр бохир усны өр төлбөр үүсгэснээс тус тус шалтгаалсан байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус сургуулийн 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 746,869.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 245,981.6 мянган төгрөгөөр, нийт зарлагыг **992,851.2** мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслийн саналыг цалин хөлс, НДШ-ийн зардлыг 206,748.3 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 25,763.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт төсвийг **1,225,363.1** мянган төгрөгөөр баталсан байна.

Тайлант онд төсвийн зохицуулалтаар цалин хөлс, НДШ-ийн зардлыг 25,722.9 мянган төгрөгөөр, үдийн цай, дотуур байрны хоолны зардлыг 18,686.8 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 24,951.1 мянган төгрөгөөр, боловсролын байгууллагын багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардлыг 6,173.5 мянган төгрөгөөр нэмэгдүүлж нийт **1,300,897.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр улсын төсвөөс 1,055,349.6 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 236,546.0 мянган төгрөг, дээд шатны төсвийн захирагчаас 5,600.0 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 2,045.6 мянган төгрөг, түрээсийн номын орлого 1,356.2 мянган төгрөг буюу нийт **1,300,897.4** мянган төгрөгийн эх үүсвэрийг урсгал үйл ажиллагаанд зарцуулахаар төлөвлөгдсөн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл **1,250,191.5** мянган төгрөг буюу 96.1 хувьтай байгаа нь цалин хөлс, ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардал 40,766.6 мянган төгрөгөөр, үдийн цай хөтөлбөрийн зардал 3,686.9 мянган төгрөгөөр, дотуур байрны үйлчилгээний зардал 4,674.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 1,577.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/							
Д/д	Хөтөлбөр	Д/д	Арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	71802 Ерөнхий боловсролын сургууль	1	80226- Байр ашиглалтын үйлчилгээ	2,138.70	2,138.70	-	100.0
		2	80312- Сургалт семинар	1,069.40	1,069.40	-	100.0
		3	81605- Эрүүл мэндийг дэмжих	2,138.70	2,138.70	-	100.0
		4	81801- Үдийн цай хөтөлбөр	42,192.70	38,505.80	(3,686.90)	91.3
		5	81806- Дотуур байрны үйлчилгээ	81,579.50	76,904.90	(4,674.60)	94.3
		6	81816- Зөв монгол хүүхэд	22,472.00	22,472.00	-	100.0
		7	81823- Боловсролын багшийн сургалт	5,128.80	5,116.60	(12.20)	99.8
		8	81827- Бичиг үсгийн боловсрол	3,220.00	3,220.00	-	100.0
		9	81834- Боловсролын стандарт сургалт	689,781.50	661,331.60	(28,449.90)	95.9
		10	81835- Сургалтын хэвийн үйл ажиллагаа	204,184.30	191,867.60	(12,316.70)	93.9
		11	81848-Сурах бичгийн түрээс	2,800.20	1,386.80	(1,413.40)	49.5
		12	83602- Дээд шатны төсвөөс	7,645.60	7,493.40	(152.20)	98.0
		13	80111-Төрийн өмчийн барилгын тогтмол зардал	236,546.00	236,546.00	-	100.0
Нийт				1,300,897.40	1,250,191.50	(50,705.90)	96.1

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Сангийн яамны 2022 оны 02 дугаар сарын 28-ны “Чиглэл хүргүүлэх тухай” албан бичгээр байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансыг хааж, нэмэлт санхүүжилттэй холбоотой гүйлгээг урсгал дансаар дамжуулан гүйцэтгэж, тайланг төсвийн гүйцэтгэлийн тайланд нэгтгэсэн байна.

3.6.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд дараах худалдан авах ажиллагааны урилгыг ТБОНӨХБАУХА тухай хуульд заасны дагуу tender.gov.mn-д цахим сайтад байршуулж, зохион байгуулсан байна. Үүнд:

/ мянган төгрөгөөр /

№	Тухайн жилд худалдан авах бараа, ажил, үйлчилгээний нэр төрөл, тоо, хэмжээ, хүчин чадал	Батлагдсан төсөв	Гэрээний дүн	Тендер шалгаруулалтын арга
1	Дотуур байрны хоол	42,192.7	31,505.8	ХТШ
2	Үдийн цай	81,579.5	44,828.4	ХТШ
	Нийт дүн	123,772.2	115,410.7	

Бэлтгэн нийлүүлэгчийг сонгон шалгаруулах нээлттэй тендер шалгаруулалт зарлаж, гүйцэтгэгчээр шалгарсан “Өглөг баян нөхөрлөл” ЗГБХН-тэй 2023 оны 08 дугаар сарын 31-ний өдөр гэрээ байгуулж, худалдан авалтыг гүйцэтгэсэн байна.

Тайлант онд хоол хүнс, цэвэрлэгээний материалыг “Өглөг баян нөхөрлөл” ЗГБХН, “Их баян бургастай” ХХК, Г.Мөнхбат, “Сант баян түшээ” ТББ, бичиг хэргийн материалыг “Хос анар” ХХК, урсгал засварын материалыг “Болор талст” ХХК-тай тус тус худалдан авах гэрээ байгуулан ажилласан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Сэлэнгэ аймгийн Сант сумын ерөнхий боловсролын сургуулийн /цаашид Сант сумын ерөнхий боловсролын сургууль гэх/ 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг тогтоосонд хугацаанд нь мэдээлж байх зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу аудитор Б.Ундаръяа гүйцэтгэж, хяналтыг Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын менежер Б.Батмөнх, дарга, тэргүүлэх аудитор Ч.Энхтуяа нар тус тус хэрэгжүүлсэн.

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 08 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,029,480.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 10,294.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Сант сумын ерөнхий боловсролын сургууль нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд дараах арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн байна. Үүнд:

- Үйл ажиллагаатай холбоотой сурталчилгаа, баяр ёслолын арга хэмжээг зохион байгуулаагүй, төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдаж аваагүй,
- Шаардлагагүй бараа материалыг их хэмжээгээр авч нөөцлөөгүй,
- Хэвлэл захиалгын төлбөр гаргалгүй ажилласан зэрэг төсвийн шууд захирагчтай хамааралтай заалтуудыг мөрдөж, батлагдсан төсвийн хүрээнд ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант онд тус сургууль нь шилэн дансны цахим хуудаст мэдээлбэл зохих 20 төрлийн 171 мэдээллээс 8 мэдээллийг хугацаа хоцроож, 45 мэдээллийг дутуу мэдээлсэн байна.

- Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын гүйлгээг 42, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын гүйлгээг 3 удаа дутуу мэдээлсэн,
- Төсөв, гүйцэтгэлтэй холбоотой мэдээллийг 5, хууль тогтоомжид заасан бусад мэдээллийг 3 удаа хугацаа хоцроож мэдээлсэн.

Дээрх зөрчлүүд нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.1, 6.4.5, 6.4.9 дэх заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны цахим хуудсанд мэдээлбэл зохих мэдээллийг хуулийн хугацаанд нь бүрэн мэдээлж байх зөвлөмж хүргүүлээ.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд бусад хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хамаарах алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Сэлэнгэ аймаг дахь Төрийн аудитын газрын 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 123 дугаар албан бичгээр “Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх тухай” захидлыг хүргүүлсэн бөгөөд тус сургуулийн 2022 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайланд хийсэн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар алдаа, зөрчил илрээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төлбөрийн цахим баримтаар баталгаажуулаагүй 7,513.6 мянган төгрөгийн төлбөр тооцоо гүйцэтгэсэн зөрчлийг давтан гаргасантай холбоотой албан шаардлага хүргүүлснийг бүрэн биелүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	7,513.6	1	7,513.6	100.0
Нийт дүн	1	7,513.6	1	7,513.6	100.0

4.6 ДАРААГИЙН АУДИТААР АНХААРАХ АСУУДАЛ

Дараах асуудлыг дээд шатны төсвийн захирагчийн санхүүгийн тайланд хийх аудитын анхааралд хандуулж байна. Үүнд:

1. БШУЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Л.Цэдэвсүрэн нь 2023 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 2/3151 дүгээр албан бичгээр тус яамны харьяа төсвийн шууд захирагч нарт “2022 оны санхүүгийн тайланд “Зөрчилгүй”, “Итгэл үзүүлсэн”, “Түүвэрт хамрагдсан” гэж дүгнээдсэн байгууллагуудын төсөв, санхүүгийн ажилтан нарт батлагдсан төсөвтөө багтаан балансын урамшууллыг Нягтлан

бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 23.2 дахь хэсгийг үндэслэн олгож болно” гэж хууль, эрхийн актад заагдаагүй **балансын урамшуулал** гэгчийг олгохыг зөвшөөрсөн байна.

Албан хаагчдын өмнөх оны ажлын үр дүнг улирал бүр дүгнэж, үндсэн цалингийн 45.0 хүртэл хувиар тооцон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон атал 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Зөрчилгүй” дүгнүүлсэн гэх үндэслэлээр тус бүр нэг сарын үндсэн цалинтай тэнцэх буюу нийт 1,982.0 мянган төгрөгийн урамшууллыг давхардуулан олгосон байна.Үүнд:

- Нягтлан бодогч Н.Энхчимэгт 1,114.0 мянган төгрөг,
- Нярав Ц.Бямбатамирт 868.0 мянган төгрөг .

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1 дэх “Төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд дараах зүйлсийг хориглоно:”, 15.1.3:“Хууль тогтоомжид зааснаас өөр хэлбэрээр тэтгэмж, шагнал, урамшуулал, дэмжлэг олгох” гэсэн заалтыг зөрчсөн байна.

2. Дээд шатны төсөв захирагчаас төсвийг зардлын эдийн засгийн ангиллаар нь бус “бараа үйлчилгээний бусад зардал” гэсэн ангиллаар бөөнд нь тусган, төлөвлөж, баталж байгаа нь төсвийг зардлын бүлэг, зүйлээр төлөвлөж, зарцуулах, зарцуулалтад хяналт тавих зарчмыг алдагдуулж байна. Иймд төсвийг бодит гүйцэтгэлтэй нь уялдуулан зардлын бүлэг, зүйл бүрээр төлөвлөж, зарцуулан гүйцэтгэж байх шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналтай холбоотой нийт **33,673.3** мянган төгрөгийн дараах алдааг залрууллаа.Үүнд:

- Санхүүгийн байдлын тайланд 13,379.7 мянган төгрөгийн газар, 6,976.4 мянган төгрөгийн бараа материалыг илүү, хандиваар ирсэн 13,317.2 мянган төгрөгийн тоног төхөөрөмжийг дутуу тайлагнасан байна.

Аудитаар нийт **25,494.7** мянган төгрөгийн зөрчил илэрснээс 777.7 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 1,478.7 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага, 23,238.3 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

1. Захирал Д.Өлзийбадрахад мэргэшлийн зэргийн нэмэгдлийг 15 хувиар тооцож 545.9 мянган төгрөгийг илүү олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ:”

20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон мэргэшлийн зэргийн нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

2.Ажлын хэсгийн санал, дүгнэлт, захирлын тушаал шийдвэргүйгээр нийгмийн ажилтан Ч.Түмэнцэцэгт ур чадварын нэмэгдэлд 231.8 мянган төгрөгийг илүү тооцож олгосон байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.*”, БШУ, ХНХ, Сангийн сайдын хамтарсан 2021 оны А/35, А/10, 9 дүгээр тушаалаар баталсан “*Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн багш, зарим албан тушаалтанд ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлт*” -ийн 8 дахь “*Багш, ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн холбогдох төсвийн захирагч шийдвэрлэнэ.*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү олгосон ур чадварын нэмэгдлийг нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

5.2 АЛБАН ШААРДЛАГА

1. Төсвийг зохистой удирдаагүй, төлбөр тооцоог урьдчилан хянаагүйн улмаас бичиг хэргийн материалын 913.4 мянган төгрөгийн өр төлбөр үүсгэсэн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь “*Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “*Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ:*”, 20.2.5 дахь “*Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*” гэсэн заалтыг байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй байх албан шаардлага хүргүүлэв.

2. Өмнөх оны санхүүгийн тайланд тусгагдаагүй 565.3 мянган төгрөгийн цалингийн өр төлбөрийг тайлант оны батлагдсан төсвөөс барагдуулж, зардлаар тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “*Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.*”, 14 дүгээр зүйлийн 14.4 дэх “*Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:*”, 14.4.3 дахь “*бүх өр төлбөр*” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийг зохистой удирдаж, өр төлбөр үүсгэхгүй ажиллах, үүссэн өр төлбөрийг бүртгэл, тайланд үнэн зөв тусгаж байх албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

Бараа материалын бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт: Тайлант онд үнэ төлбөргүйгээр хүлээн авсан нийт 3,416.0 мянган төгрөг /Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 3,346.0 мянган төгрөгийн сургалтын хэрэглэгдэхүүн, Дэлхийн зөн ОУБ-аас 70.0 мянган төгрөгийн бараа материал/-ийн бараа материалыг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь “Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ.” 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.2 Өгсөн зөвлөмж: Дээрх бараа материалыг 2024 оны 2 дугаар улиралд багтааж бүртгэл тайланд тусгах.

1.3 Илрүүлэлт: Санхүүгийн тайлангаарх үдийн цай, дотуур байрны хоолны материалын орлогын дүн нярвын тайлангаас 2,709.5 мянган төгрөгөөр, зарлагын дүн 17,112.8 мянган төгрөгөөр зөрүүтэй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно.”, 20.2 дахь “Нягтлан бодогч нь дараах үүрэг хүлээнэ.”, 20.2.5 дахь “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах” гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

1.4 Өгсөн зөвлөмж: Хүнсний материалын худалдан авалт, зарцуулалтыг тухай бүр бүртгэл тайланд тусгаж байх.

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5² дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 15 -ны өдрийн дотор тус тус төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Газрыг илүү дүнгээр тайлагнасан.	1	13,379.7			1	13,379.7	1	13,379.7				

² Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

Бараа материалыг илүү дүнгээр тайлагнасан.	1	6,976.4			1	6,976.4	1	6,976.4				
Хандиваар ирсэн хөрөнгийг дутуу тайлагнасан.	1	13,317.2	1	13,317.2	-	-	1	13,317.2				
Дүн	3	33,673.3	1	13,317.2	2	20,356.1	3	33,673.3				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Цалингийн нэмэгдлийг илүү тооцож олгосон.	1	777.7	1	777.7								
Өр төлбөр үүсгэсэн.	1	913.4			1	913.4						
Өмнөх оны өр төлбөрийг тайлант оны зардлаар тайлагнасан.	1	565.3			1	565.3						
Няравын тайлангийн хүнсний материалын орлого, зарлага зөрүүтэй тайлагнагдсан.	1	19,822.3					1	19,822.3				
Бараа материалыг дутуу бүртгэсэн.	1	3,416.0					1	3,416.0				
Дүн	4	25,494.7	1	777.7	2	1,478.7	2	23,238.3				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансанд 8 мэдээллийг хугацаа хоцроож, 45 мэдээллийг дутуу мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авах ажиллагаатай холбоотой.	1	-					1	-
Дүн	1	-					1	-
Нийт дүн	2	-					2	-